



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР**

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2011 ОНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОЙМ
МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН 2011 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ**

**УЛААНБААТАР ХОТ
2012.03.26**

А. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2011 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ:

2011 оны байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр нийт 252 өдрийн арилжаа хийгдсэн бөгөөд нийт 148 компанийн 122.8 сая ширхэг хувьцааг 109.1 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын 2.4 сая ширхэг бондыг 236.7 тэрбум төгрөгөөр, компанийн 439.5 мянган ширхэг бондыг 4.4 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагджээ.

Нийт 350.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 125.6 сая ширхэг үнэт цаасыг арилжаалсан байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 257.4 тэрбум төгрөгөөр буюу 3.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График-1



2011 онд үнэт цаасны арилжааны дүн огцом өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлүүд:

- Дотоодын зах зээлд хөрөнгө оруулагчдийн тооны өсөлт;
- Нэгж хувьцааны үнэ өмнөх онтой харьцуулахад өссөн байдал;
- Засгийн газрын болон компанийн бонд, IPO, нэмж гаргасан хувьцаа зэрэг нь зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.


Тайлант хугацаанд нийт 148 компанийн үнэт цаас арилжаалагдсанаас 129 компанийн үнэт цаасны ханш өсч, 13 компанийн үнэт цаасны ханш буурч, 6 компанийн үнэт цаасны ханш тогтмол байв.

Анхдагч зах зээлийн арилжаагаар “Шарын гол” ХК-ийн нэмж гаргасан 11,117 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,646,257 ширхэг хувьцааг 18,301,439,069 төгрөгөөр, “Силикат” ХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 225 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 16,222,300 ширхэг хувьцааг 3,650,042,500 төгрөгөөр тус тус арилжаалагдсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 21.5 хувийг эзэлжээ.

2011 оны байдлаар нийт 48.2 мянган ширхэг хэлцэл хийгдсэн байгаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График-2

Хийгдсэн хэлцэл (мянган ширхэг)




Зах зээлийн үнэлгээ 2011 оны байдлаар 2 их наяд 168 тэрбум 569 сая 984 мянга 199 төгрөгт хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 794.6 тэрбум төгрөгөөр буюу 57.8 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын томоохон компаниудын хувьцаа олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргасан нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг дотоодын хөрөнгийн зах зээл зүй ёсоор татаж, нэгж үнэт цаасны үнэд эерэг нөлөөлснөөр тайлант хугацаанд зах зээлийн үнэлгээ өсчээ.

Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компанид Таван толгой ХК /579.3 тэрбум/, АПУ ХК /312 тэрбум/, Багануур ХК /274.8 тэрбум/, Шивээ овоо ХК /205.3 тэрбум/, Шарын гол ХК /96.7 тэрбум/ зэрэг хувьцаат компаниуд орж байна.


График-3

Зах зээлийн үнэлгээ (тэрбум.төг)



Хөрөнгийн зах зээлийн ерөнхий хандлагыг илэрхийлж буй ТОП-20 индекс 2011 оны жилийн эцсийн дүнгээр 21,687.57 нэгж болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,927.76 нэгжээр буюу 46.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 32954.97 нэгж, доод үзүүлэлт 14686.64 нэгж, дундаж үзүүлэлт 21420.81 нэгж үзүүлэлттэй байсан байна.


График-4



2011 оны байдлаар салбарын индексийн үзүүлэлтүүдийг авч үзвэл аж үйлдвэрийн салбарын индекс 2126.63, Хөдөө аж ахуйн салбарын индекс 10816.3, Уул уурхайн салбарын индекс 7837.37, Худалдаа үйлчилгээний салбарын индекс 895.25 нэгж, барилга тээврийн салбарын индекс 4969.01 нэгжтэй байна.

Хувьцааны хөрвөх чадвар буюу эргэлтийг “ҮЦТТТХТ” ХХК-д хадгалагдаж буй хувьцааны нийт ширхэгийг тухайн онуудад арилжигдсан хувьцааны тоо ширхэгт харьцуулан хувиар тооцож үзвэл дараахь байдалтай байна.

График-5



Судалгаанаас харахад 2011 оны байдлаар нийт бүртгэлтэй хувьцааны 4.8 хувь нь зах зээл дээр идэвхтэй арилжигдсан байна. Эргэлт бага байгаа шалтгааныг их хувьчлалын дараа 1993-2005 оны хугацаанд хувьцаат компанийн гаргасан нийт хувьцаа цөөн хэдэн хувьцаа эзэмшигчдийн гарт төвлөрсөн, үүнтэй уялдан хөрөнгийн зах зээлийн тухай иргэдийн мэдлэг

дутмаг, идэвх, санхүүгийн салбарт банкны салбар давамгайлсан, үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хангалттай нийлүүлэгдэхгүй байгаатай холбоотой гэж үзлээ.


Үнэт цаасны зах зээлийн 2011 оны жилийн эцсийн байдлаарх төлбөр, тооцоо хадгаламжийн төлөв:

2011 оны жилийн эцсийн байдлаар “ҮЦТТХТ” ХХК-д нийт 17,941,104,608 ширхэг хувьцаа хадгалагдаж байгаа бөгөөд үүнээс төрийн мэдлийн хувьцаа 85 хувийг, төрийн мэдлийн бус хувьцаа 14.2 хувийг, Засгийн газрын болон компанийн бонд зэрэг бусад үнэт цаас 8 хувийг тус тус эзэлж байна.

Нийт 7,470,900.0 ширхэг бонд хадгалагдаж байгаагаас 4,238,000 ширхэг нь засгийн газрын бонд, 3,232,900.0 ширхэг нь компанийн бонд байна.

Тайлант хугацаанд үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв нийт 3511 харилцагчийн дансаар 8,752 удаагийн 406.9 тэрбум төгрөгийн орлого, 8648 харилцагчийн дансаар 12,663 удаагийн 404.01 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус хийж гүйцэтгэжээ.

График-6



Нийт 9,439 харилцагчийн дансанд 21,415 удаагийн 811.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийгдсэн байна. Дээрх дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.8 тэрбум төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 129,138 данс нээгдсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 119,385 мянган дансаар нэмэгдсэн байна. Данс их хэмжээгээр нээсэн нь “Эрдэнэс Таван

толгой” ХК-ийн 536 ширхэг хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх Засгийн газрын шийдвэртэй холбоотой.

2011 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт 564,550 ширхэг данс нээгдээд байна.

Хүснэгт-1

Он	Дансны төрөл			Харилцагчийн төрөл				Нийт	Холболт
	Шинэ	ХОЭБ	Хүсэлт	Иргэн		ААН			
				Монгол	Гадаад	Монгол	Гадаад		
2003	395	4350	3	4738	3	2	2	14605	9857
2004	450	6355	10	6786	9	10	-	44409	37594
2005	496	4431	12	4894	19	12	2	6780	1841
2006	2303	13908	22	16158	32	18	4	18435	2202
2007	50220	20579	41	70432	326	25	17	75290	4449
2008	2654	19077	77	21538	121	50	22	25320	3512
2009	671	8240	34	8803	74	25	9	10031	1086
2010	1310	4846	69	5884	203	46	23	9753	3528
2011	108909	4357	1212	113253	501	685	39	129138	14660

Тайлант жилд нийт үнэт цаасны арилжаанд оролцсон тоо, арилжаанд эзлэх хувь хэмжээг хөрөнгө оруулагчдын төрөл тус бүрээр авч үзвэл дараахь байдалтай байна.

Хүснэгт -2

Он	Нийт гүйлгээ /тэрбум, төг/	Гадаадын х/этгээд		Гадаадын иргэн	
		Арилжаанд оролцсон тоо	Дүн /тэрбум, төг/	Арилжаанд оролцсон тоо	Дүн /тэрбум, төг/
2006	18.0	477	4.3	917	0.6
2007	102.4	3127	34.1	5091	4.3
2008	62.3	1545	11.0	3989	4.0
2009	23.2	882	6.5	1129	0.9
2010	92.9	1672	50.1	3414	7.6
2011	350.2	3097	71.7	8730	11.1
Он	Арилжаанд оролцсон тоо	Дотоодын х/этгээд		Дотоодын иргэн	
		Дүн /тэрбум, төг/	Арилжаанд оролцсон тоо	Дүн /тэрбум, төг/	Арилжаанд оролцсон тоо
2006	1802	6.8	8397	6.3	
2007	3863	46.7	16824	17.3	
2008	4800	10.8	23640	36.5	
2009	2291	5.9	9663	9.9	
2010	3396	27.9	17037	7.2	
2011	4464	245.6	31916	21.7	

2011 онд гадаадын хуулийн этгээд, хувь хүмүүс нийт 11,827 удаагийн гүйлгээгээр 82.8 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь нийт арилжааны дүнд 23,0 хувийг эзэлж байгаа нь тооны хувьд харьцангуй бага боловч гадны хөрөнгө оруулагчид Монголын үнэт цаасны зах зээлд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгааг харуулж байна.

Дотоодын хуулийн этгээд, хувь хүмүүс 36,380 удаагийн гүйлгээгээр 267.3 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байгаа нь нийт арилжааны дүнд 77,0 хувийг эзэлж байна.

Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг арилжааны бусаар шилжүүлсэн гүйлгээний мэдээлэл:

2011 оны байдлаар 158 хувьцаат компанийн 721,255 ширхэг үнэт цаасыг арилжааны бус хэлцлээр шилжүүлсэн байна. Үүнд:

Өв залгамжлалаар нийт 1,495 гүйлгээ хийгдэж 127 ХК-ийн 180,793 ширхэг хувьцаа, бэлэглэлээр 74 гүйлгээ хийгдэж 31 ХК-ийн 540,462 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлжээ.

Үүргийн гүйцэтгэл хангуулах тухайд 2011 онд нийт 69,237,128 ширхэг үнэт цаасыг зээлийн барьцаанд тусгаарлаж, зээлийн барьцаанаас нийт 77,044,509 ширхэг үнэт цаас чөлөөлжээ. 2011 оны жилийн эцсийн байдлаар 14 ХК-ийн 39,941,540 ширхэг үнэт цаас зээлийн барьцаанд тусгаарлагджээ.

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид:

2011 оны жилийн эцсийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 88, зэрэглэл тогтоох 1 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 22, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 17 компани байна.

Хороо тайлант жилд 40 компанид брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 5 компанид хөрөнгө оруулалтын зөвлөхийн болон андеррайтерийн тусгай зөвшөөрлийг нэмж олгосон бол 8 компанийн гүйцэтгэх захирлыг томилох асуудлыг хянан шийдвэрлээд байна.

График-7




2011 онд нийт 21 компанийн үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасан бол тусгай зөвшөөрөлтэй 14 компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтийг болон 5 компанийн оноосон нэрээ өөрчлөх асуудлыг тус тус хянан шийдвэрлээд байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, иргэдэд брокер, дилерийн үйлчилгээг чанар хүртээмжтэй хүргэх зорилгоор тайлант жилд нийт 6 компаниудад хөдөө орон нутагт брокер, дилерийн үйлчилгээ үзүүлэх салбарын зөвшөөрлийг өгсөн ба тэдгээр нь давхардсан тоогоор 12 аймагт үйл ажиллагаа явуулж байна.

2011 оны жилийн эцсийн байдлаар 330 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэйгээс төрийн өмчийн 23, төрийн өмчийн оролцоотой 29, хувийн өмчийн 278 компани байна.


График-8



2011 оны байдлаар нийт 28 хувьцаат компани 74.25 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад тараасан ногдол ашгийн үнийн дүн 58.4 хувиар өссөн байна.

График-9

Ногдол ашиг тараалт



Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдсэн байна. Хэдийгээр ногдол ашиг өгч буй компаниудын тоо харилцан адилгүй байгаа ч тарааж буй ногдол ашгийн дүн ба нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2005 оноос 2010 оны хооронд нийт 16 компани Хороонд үнэт цаасаа бүртгүүлэн IPO, SPO хийгээд байгаа бөгөөд нийт 83.3 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн нь арилжааны нийт дүнд 31.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт-3

д/д	Компанийн нэр	Тоо ширхэг	Татан төвлөрүүлсэн хөрөнгө /төгрөг/	Арилжаа явагдсан хугацаа	
				эхэлсэн	дууссан
1	Зоос банк	1,999,768.0	2,022,528,900.0	2006.02.14	2006.02.21
2	Монгол шилтгээн	1,000,000.0	800,000,000.0	2005.06.17	2006.11.21
3	БиДиСек	8,400,014.0	3,375,346,500.0	2006.06.23	2006.12.08
4	Оллоо	5,820,299.0	582,029,900.0	2007.09.28	2007.10.23
5	Хай Би Ойл	6,738,361.0	1,128,474,814.0	2007.05.03	2007.05.03
6	Монинжбар	10,000,000.0	1,000,000,000.0	2007.01.18	2007.06.04
7	Женко тур бюро	78,895,885.0	8,259,239,676.0	2006.01.18	2009.06.09
8	Туул сонгино усны нөөц	13,200,000.0	13,200,061,250.0	2007.12.03	2007.12.25
9	Гермесцентр	23,562,900.0	2,356,290,000.0	2008.05.19	2008.05.22

10	Анод банк	18,618,171.0	20,107,624,680.0	2008.05.28	2008.05.28
11	Ремикон	50,488,202.0	5,048,820,200.0	2008.05.21	2009.09.14
12	Хөх ган	30,395,272.0	3,195,456,280.0	2008.08.01	2008.08.01
13	Монфреш шүүс	692,432.0	69,243,200.0	2008.10.29	2009.01.06
14	Нако түлш	1,180,195.0	270,264,655.0	2010.10.11	2010.10.11
15	Силикат	16,222,300.0	3,650,017,500.0	2011.08.09	2011.08.09
16	Шарын гол	1,646,257.0	18,301,439,069.0	2011.10.17	2011.10.17
	Нийт дүн	268,860,056.0	83,366,836,624.0		
	Нийт арилжаанд эзлэх %	36.4	31.8		

Хүснэгт-4

д/д	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	Зоос банк	Банк санхүү
2	Монгол шилтгээн	Зочид буудал зоогийн газар
3	БиДиСек	Санхүүгийн зуучлал
4	Оллоо	Мэдээлэл технологи
5	Хай Би Ойл	Тос тосолгооны материал
6	Монинжбар	Барилга угсралт
7	Женко тур бюро	Зочид буудал амралт зугаалга
8	Туул сонгино усны нөөц	Ус боловсруулалт
9	Гермесцентр	Худалдаа үйлчилгээ
10	Анод банк	Банк санхүү
11	Ремикон	Цемент үйлдвэрлэл
12	Хөх ган	Төмөр хийц
13	Монфреш шүүс	Ус ундаа үйлдвэрлэл
14	Нако түлш	Түлш боловсруулах
15	Силикат	Барилгын хийц
16	Шарын гол	Шарын гол

Дээрх IPO, SPO хийсэн компаниудыг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл боловсруулах салбарын аж ахуй нэгжүүд 50 хувийг эзэлж байгаа нь энэ салбарын аж ахуй нэгжүүд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож түүгээрээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн боломжтойг харуулж байна.

IPO, SPO хийсэн компанийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл:



2011 онд “Шарын гол” ХК, “Силикат” ХК-иуд анхдагч зах зээл дээр хувьцаа нэмж гаргах зөвшөөрлийг Хорооноос авсан бөгөөд “Шарын гол” ХК, “Силикат” ХК-ийн нэмж гаргасан хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр амжилттай арилжаалагдаж, нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 21.5 хувийг эзэлжээ.

Тайлант хугацаанд “Жаст агро” компани нэг бүр нь 10.0 мянган төгрөгийн үнэтэй 3.0 сая ширхэг, нийт 30.0 тэрбум төгрөгийн “Монгол мах” бондыг анхдагч зээл дээр арилжаалах зөвшөөрлийг Хорооноос авсан бөгөөд эхний 10.0 тэрбум төгрөгийн бонд энэ оны 09 дүгээр сараас арилжаалагдаж нийт 439.5 мянган ширхэг бондыг 4.4 тэрбум төгрөгөөр арилжаалаад байна.

Б. 2011 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ:

2011 оны 4 дүгээр улирлын байдлаар мэргэжлийн оролцогч байгууллагуудын актив, пассивын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараахь байдалтай байна:

2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 80 тусгай зөвшөөрөл эзэмшигч компани санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдсан бөгөөд мэргэжлийн оролцогч байгууллагын нийт активын хэмжээ 2,198.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 2,165.8 тэрбум төгрөгөөр буюу 67.3 дахин өссөн үзүүлэлттэй байв.

Энэ нь 2011 онд хөрөнгийн зах зээлд хандах сонирхол идэвхжиж, Хорооноос брокер, дилерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд хөрөнгийн зах зээлийг арилжааны банкууд сонирхож, тухайн банк өөрөө болон түүний охин компаниуд Банкны тухай хуулийн 6.2.7-д зааснаар харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ эрхлэх болон андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нь салбарын нийт активын дүнг эрс өсгөх үндсэн шалтгаан болжээ. /2011 онд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан “Голомт банк” ХХК-ийн нийт хөрөнгө нь салбарын нийт активын дүнгийн 96,9 хувийг дангаараа эзэлж байна/

Салбарын хэмжээнд нийт хөрөнгийн 99 хувийг хүснэгтэд буй доорхи 11 мэргэжлийн оролцогч компани бүрдүүлж байна:

№	Мэргэжлийн оролцогч байгууллага	Нийт хөрөнгө
1	Голомт банк ХХК/андеррайтер/	2,130,862,739,049.27
2	ҮЦТТГХТ ХХК	15,666,730,373.23
3	Ти Ди Би Капитал ХХК	6,964,310,358.61
4	Би Ди Сек ХК	9,887,113,592.62
5	Монголын хөрөнгийн бирж ХК	9,646,897,115.16
6	Нортенсек	5,005,950,935.00
7	Юнайгэд секьюритс 3	3,165,935,905.74
8	Фронттиер	2,133,779,340.09
9	Эй Жэй Эй Эйч	1,271,196,804.21
10	Туушин Инвест	1,217,391,608.40
11	Евроази капитал монголиа	1,115,184,860.22
	Нийт дүн	2,186,937,229,942.55
	Салбарын нийт хөрөнгийн дүн	2,198,454,568,995.17

Нийт активын дүнд эргэлтийн хөрөнгө 98 хувь, эргэлтийн бус хөрөнгийн дүн 2.0 хувийг тус тус эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгийн дүн 82 дахин, эргэлтийн бус хөрөнгийн дүн 6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Эргэлтийн хөрөнгийн бүтцийг задалж үзвэл мөнгөн хөрөнгө 25%, богино хугацаат хөрөнгө оруулалт 16%, авлага 59%, бараа материал 0.1%, урьдчилж төлсөн зардал 0.2% -иар тус тус бүрдүүлжээ.

Эргэлтийн бус хөрөнгийг үндсэн хөрөнгө 88.2%, бусад үндсэн хөрөнгө 1.4%, биет бус хөрөнгө 3.4%, бусад хөрөнгө 7%-иар тус тус бүрдүүлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 36.5 тэрбум төгрөгөөр буюу 6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-5

Балансын хураангуй	2011/04	2010/04	Өөрчлөлт
	2,198,454,568,995.1	32,620,664,744.2	2,165,833,904,250.8
	7	9	8
Эргэлтийн хөрөнгө	2,155,350,962,602.0	26,019,898,903.9	2,129,331,063,698.0
	1	4	7
Мөнгөн хөрөнгө	541,969,481,465.06	16,789,470,157.4	525,180,011,307.58
		8	
Богино хугацаат хөрөнгө	344,874,274,455.58	5,584,278,152.67	339,289,996,302.91
Оруулалт			
Авлага	1,256,329,948,642.3	1,727,150,359.33	1,254,602,798,283.0
	8		5
Бараа материал	2,580,017,200.72	129,319,222.46	2,450,697,978.26
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,055,947,975.00	275,011,003.97	3,780,936,971.03
Бусад /Эрсдлийн сан /	5,541,292,863.27		4,026,622,855.24
		1,514,670,008.03	
Эргэлтийн бус хөрөнгө	43,103,606,393.15	6,600,765,840.35	36,502,840,552.80

Өр төлбөр ба эзэмшигчдийн Өмч	2,198,454,568,995.17	32,620,664,744.29	2,165,833,904,250.88
Өр төлбөр	1,970,898,817,462.61	14,654,175,416.37	1,956,244,642,046.24
Богино хугацаат өр төлбөр	1,906,410,137,529.99	14,529,866,561.47	1,891,880,270,968.52
Урт хугацаат өр төлбөр	64,488,679,932.62	124,308,854.90	64,364,371,077.72
Эзэмшигчдийн өмч	227,555,751,532.56	17,966,489,327.92	209,589,262,204.63
Өмч: Төрийн өмч	2,335,886,599.18	2,335,886,599.18	0.00
Хувийн өмч	22,290,173,260.73	10,225,361,088.09	12,064,812,172.64
Халаасны хувьцаа	24,591,542,533.78		24,591,542,533.78
Хувьцаат капиталын дүн	49,217,602,393.69	12,561,247,687.27	36,656,354,706.42
Нэмж төлөгдсөн Капитал	26,090,896,468.06	3,038,006,605.72	23,052,889,862.34
Дахин үнэлгээний нөөц	1,370,260,139.26	117,260,289.79	1,252,999,849.47
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	54,566,135,435.18	526,828,135.05	54,039,307,300.13
Үнэт цаасны хэрэгжээгүй олз, гарз	2,156,359,526.71	1,866,723,757.01	289,635,769.70
Эрсдлийн сан	274,221,012.23	162,627,396.41	111,593,615.82
Хуримтлагдсан ашиг, алдагдал	93,880,276,557.43	-306,204,543.33	94,186,481,100.75
Тайлангийн үеийн Өмнөх үеийн	33,681,569,768.91	1,126,622,903.08	32,554,946,865.83
	60,198,706,788.52	-1,432,827,446.41	61,631,534,234.93
Үүнээс: цөөнхийн хувь	0.00	0.00	0.00
Оролцоо			

2011 оны 4 дүгээр улирлын нийт пассивын дүнд өр төлбөрийн дүн 89.65 хувь, эзэмшигчийн өмчийн дүн 10.35 хувийг тус тус эзэлж байна.

Өр төлбөрийн нийт дүнд богино хугацаат өр төлбөр 96.73 хувийг, урт хугацаат өр төлбөр 3.27 хувийг тус тус эзэлжээ.

Өр төлбөрийн дүн өмнөх оны мөн үеийнхээс даруй 1,956.2 тэрбум төгрөг буюу 134 дахин нэмэгдсэн байна.

Эзэмшигчийн өмчийн дүнд хувьцаат капиталын дүн 21.6 хувь, хуримтлагдсан ашиг, алдагдал 41.26 хувь, бусад 37.14 хувийг тус тус эзэлж байна.

Нийт салбарын активын хэмжээ 2,198.4 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын салбарын нийт активын дүнгээс даруй 27 дахин, хадгаламж зээлийн салбарын нийт активын дүнгээс

даруй 35.5, Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын дүнгээс даруй 10.7 дахин өссөн үзүүлэлттэй байв.

2011 оны 4 дүгээр улирлын байдлаар мэргэжлийн оролцогч байгууллагуудын орлого, үр дүнгийн тайлангийн нэгтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараахь байдалтай байна:

Тайлант хугацааны эцсээр үндсэн үйл ажиллагааны орлого 1,747.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 292 дахин өсчээ.

Үндсэн үйл ажиллагааны нийт орлогын 98 хувийг “Голомт банк” ХХК/андеррайтер/, “Би Ди Сек” ХК, “МХБ” ХК, “Ти Ди Би” ХХК, “ҮЦТТГХТ” ХХК зэрэг 5 компани бүрдүүлж салбарын хэмжээнд ашигтай үзүүлэлт гарсан боловч 2011 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 40 компани алдагдалтай ажиллажээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогын бүтцийг үйл ажиллагааны орлого 0.5 хувь, хөрөнгө оруулалтын орлого 9.5 хувь, борлуулалтын бусад орлого 90.0 хувиар тус тус бүрдүүлж байна. Нийт ашиг 1,746.1 тэрбум төгрөг, нийт үйл ажиллагааны зардал 1,702.1 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт салбарын хэмжээнд 33.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж 9.8 тэрбум төгрөгийн орлогын татвар төлжээ.

Салбарын хэмжээнд нийт цэвэр ашгийн 99 хувийг “Голомт банк” ХХК /андеррайтер/, “Би Ди Сек” ХК, “ҮЦТТГХТ” ХХК, “Ти Ди Би Капитал”, “МХБ” ХК зэрэг 5 компани бүрдүүлснээс Голомт банк ХХК дангаараа 92 хувийг /30,988,297,148.64 төгрөг/ эзэлж байна.

Хүснэгт-6

Орлого, үр дүнгийн тайлангийн хураангуй	Нэгдсэн дүн
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,747,844,714,713.74
Үйл ажиллагааны орлого	8,696,674,249.34
Хөрөнгө оруулалтын орлого	166,085,326,409.29
Бусад	1,573,062,714,055.11
Борлуулалтын хөнгөлөлт	515,500.00
Борлуулалтын хорогдол ба буцаалт	13,067,505.05
Үндсэн үйл ажиллагааны цэвэр борлуулалтын орлогын дүн	1,747,831,131,708.69
Борлуулсан үнэт цаасны өртөг	1,637,597,930.90
Нийт ашиг (алдагдал)	1,746,193,533,777.79
Үйл ажиллагаа (борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	1,702,102,010,128.17
Үйл ажиллагааны зардал	160,793,091,411.65
Шимтгэл	1,693,426,380.98

Бусад зардал	1,539,615,492,335.54
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	44,091,523,649.62
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(605,117,253.36)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	43,486,406,396.27
Орлогын татварын зардал	9,811,467,253.61
Татварын дараах ашиг (алдагдал)	33,674,939,142.66
Цөөнхөд ноогдох хувь	
Ердийн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	33,674,939,142.66
Онцгой шинжтэй зүйл – цэвэр	(9,000,000.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	33,683,939,142.66
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР